

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль	Энэ хуулийн зорилт нь хүний болон мал эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур /цаашид “эм” гэх/, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино	6.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналттай холбоотой үйл ажиллагааг төрийн зүгээс нэгдсэн зохицуулалтаар хангана. 6.2.Энэ хуулийн 6.1-д заасан төрийн зохицуулалтыг дараахь үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ: 6.2.1.эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа; 6.2.2.үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл 6.2.3.импорт, экспортын лиценз, хяналт, зохицуулалт; 6.2.8.эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналт; 6.2.9.зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалт, хяналт; 6.2.10.эмнэлгийн мэргэжилтэн болон олон нийтэд зориулсан эмийн талаархи хараат бус, бодит мэдээлэл. 6.3.Энэ хуулийн 6.2-т заасан зохицуулалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.